



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70512121, 70518232

2024.04.08 № 01/404
танай _____-ны № _____-т

「МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН」
ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын 2024 оны 01 дүгээр улирлын мэдээг нэгтгэж хүргүүлэв.

Хавсралт 5-хуудастай.



М.ИДЭРБАТ

2224060088



СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 06

Баруун-Урт сум

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 06 дугаар тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийн 2024 оны 1 дүгээр улирлын тайланг хэлэлцүүлэх тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийн 2024 оны 1 дүгээр улирлын тайланг хэлэлцүүлэх явцад Засаг даргын зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг тусгаж тайланг хугацаанд нь Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Амарзаяа, мэргэжилтэн Б.Бямбасүрэн нарт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2224333012

ТАНИЛЦУУЛГА

Иргэдээс Сүхбаатар аймгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тухай

(2024 оны 1 дүгээр улирлын байдлаар)

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 08 тоот албан даалгаврын дагуу аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас 2024 оны 1 дүгээр улиралын байдлаар ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайланг нэгтгэн танилцуулж байна.

Тайлант хугацаанд аймгийн нийт төрийн захиргааны байгууллагад 1,439 өргөдөл гомдол, санал хүсэлт, талархал ирсний 1,359 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлт 94.4 хувийн үзүүлэлттэй байна. Шийдвэрлэх боломжгүй 1, хугацаа болоогүй 79 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд судлагдаж байна.

Аймгийн хэмжээний нийт төрийн захиргааны байгууллагад иргэдээс хандаж гаргасан өргөдлийг агуулгаар нь ангилахад Боловсрол шинжлэх ухааны газар, Хүнс хөдөө аж ахуйн газарт хандаж гарсан өргөдөл, хүсэлт зонхилж байна.

2024 оны 1 дүгээр улиралд аймгийн Засаг даргад хандаж 14 өргөдөл, гомдол ирсний 9 өргөдөл нь бичгээр, 3 өргөдөл нь Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжин шилжиж ирсэн бөгөөд нийт өргөдлийн шийдвэрлэлт 96.8 хувийн үзүүлэлттэй байна. Ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд 2 иргэнд 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн эмчилгээний болон буцалтгүй тусламж, дэмжлэг олгосон.

Аймгийн нийт төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын төрлийг нэгдүгээр, өргөдлийн шийдвэрлэлтийг хоёрдугаар, нийт өргөдлийн агуулга болон зонхилж байгаа асуудлыг гуравдугаар хавсралтаар тус тус харуулав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн
01/404 тоот албан бичгийн нэгдүгээр хавсралт



2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл				Хүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр
Тайлбар:	Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн
Сүхбаатар	0	1	2	1436	1109	129	41	3	157

2024 оны 04 дүгээр сарын 01 ны өдрийн
01/04 тоот албан бичгийн хоёрдугаар хавсралт



2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

Шийдвэрлэлтийн байдал										
Шийдвэрлэж хариу өгсөн					Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн (30 хоног)	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн (60 хоног)	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй
Аймгийн нэр	Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо				
Сүхбаатар	225	50	121	946	12	5	0	0	79	1

-----oOo-----

Аймгийн Засаг даргын
2024 оны 14 дүгээр сарын 02-ны өдрийн
01/1404 тоот албан бичгийн гуравдугаар хавсралт



2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

№	Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Худалдан авах ажиллагааны чиглэлээр	1	0.06	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах.

-----oOo-----